

## Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл

Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн нэгдэл нь анх 1955 онд Зүүн хорооны 30 ортой эмнэлгийг 26 орон тоотойгоор нээн ажиглуулсан.

1959 оноос дотор, мэс засал, хүүхэд, эмэгтэйчүүд, нүд зэрэг нарийн мэргэжлийн кабинетуудыг 12 их эмч, 4 бага эмч, 11 сувилагч нийт 45 орон тоотойгоор нээж амбулаторийн үйлчилгээ явуулж байгаад 1966 онд хүүхдийн хэсгүүд райончлогдоход шилжин ирж ажилласан.

1972 онд "Найрамдлын районы амбулатори" нэртэй байгуулагдаж Найрамдлын районы хүүхдийн эмнэлэг, зөвлөх төв болон ажиллаж байгаад 1997 онд дүүргийн эмнэлэг, хүүхдийн эмнэлэг менежментийн хувьчлалаар тусад аа ажиллах болсноор зөвлөх төв татан буугдаж, Эрүүл мэндийн нэгдлийг шинээр зохион байгуулсан.

2000 онд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргаар Эрүүл мэндийн 9,10

15-р төвүүдийг татан буулгаж, Эрүүл мэндийн нэгдлийг шинээр зохион байгуулсан.

ЭМН-н харьяанд 1,2-р салбар амбулатори, поликлиникийн байгуулж, дүүргийн 23 өрхийн, Гачуурт, Хонхор хорооны эмнэлгүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган дүүргийн 144,4 га нутаг дэвсгэрийн 214,000 гаруй хүнд амд анхан шатны болон 2 дахь шатлалын тусламж үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ 16 хүртэлх насны хүүхдэд түргэн тусламжийн үйлчилгээг 24 цагаар үзүүлж байна.

Эрүүл мэндийн нэгдэл нь

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Хүний нөөц, чанар, статистик

Санхүү, ханган нийлүүлэлт

Сувилахуйн гэсэн 5 албадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна

Тус байгууллагын үе үеийн дарга нар

С.Абденбай /1972-1992/

Д.Бааст /1992-1993/

Д.Батмөнх /1993-1998/

П.Буудай / 1998-2000/

Б.Пунцаг /2000 оноос хүртэл/

2000 оны байдлаар нийт 311 эмч, ажиллагсадтай байсан бол 2007 оны байдлаар энэ тоо 441 болж 39.2%-р өссөн байна.

Сүүлийн 10 жилд ахмад, дотоод шүүрэл, нүд, ДОХ, БЗДХ, арьс харшил,уламжлалт эмчилгээ, сэтгэц,наркологи, өсвөр үе, эмэгтэйчүүдийн ЭХО, зэрэг нарийн мэргэжлийн 15 кабинет шинээр байгуулагдан, үйлчлэх хүрээний хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.